



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/24

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль” -ийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а” заалт, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2013 оны А/367 дугаар тушаалын 4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дөргөний усан цахилгаан станц Төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, ус ашиглалтын байдал, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хэрэгжилт, Байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцах, 2020 оны ус ашиглах гэрээ дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Л.Батбаяр- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Гишүүд:

Х.Баасанхүү - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтий хэлтсийн мэргэжилтэн

Д.Уранчимэг -Хар ус нуур орчмын улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны мэргэжилтэн

Х.Мөнхжаргал- Мэргэжлийн хяналтын газрын байцаагч

З.Бахатбол- Ус цаг уур орчны шинжилгээний төвийн инженер

Т.Ням- Дөргөн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Zax A/24 Ch

02 0133

М.Энхтайван-Хар нуур-Ховд голын сав
газрын захиргааны ахлах мэргэжилтэн

Э.Оюунтунгалаг- Хар нуур-Ховд голын сав
газрын захиргааны мэргэжилтэн

Т.Бямбажаргал - Байгаль орчин, аялал
жуулчлалын газрын мэргэжилтэн


Нарийн бичгийн
дарга:

Р.Энхсүрэн - Хар нуур-Ховд голын сав
газрын захиргааны дарга

2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хэрэгжилт, Байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөөний хэрэгжилт, 2020 оны ус ашиглах гэрээний хэрэгжилт, ус ашиглалтын нөхцөл байдалд хийсэн хяналт, шалгалтын тайланг 2021 оны 02 дугаар сарын 05-ны дотор танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Л.Батбаяр/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН